

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ ХУВААРИЛАЛТ ГҮЙЦЭТГЭЛ”

АУДИТЫН КОД: ХӨА-2023/53-16-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579



Тайланг бэлтгэсэн:

**Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар**

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Б.Давааням

Аудитор

Г.Ичинхорлоо

*Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.*

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2023 оны 07 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт, хамрах хүрээ, аудитын арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийн батлагдсан төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1. Санхүүжилтийн хуваарийг журмын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна.

1.2 Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журамд заасан үзүүлэлтийг харгалзан сумдад хуваарилсан байна.

Бүлэг 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна.

2.1 Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж 105.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна.

Дүгнэлт

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
САС	Сонгуулийн автоматжуулсан систем



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 1/26

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/61 дугаар тушаал, 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Давааням/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дах хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/61 “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Сонгуулийн хороо болон холбогдох албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулж, үнэн зөв тайлагнаж, хяналт тавьсан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг аймгийн Сонгуулийн хороо, Баянзүрх, Тосонцэнгэл сумын хэсгийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газарт Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Монгол Улсын Төрийн аудитын стандарт–Гүйцэтгэлийн аудит MNS 6817:2020, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа, тодруулга авах, лавлагаа авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”
- СЕХ-ноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах Б.Давааням, Г.Ичинхорлоо нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 6 дугаар сарын 19-ны өдрөөс 7 дугаар сарын 18-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Хөвсгөл аймагт орон нутгийн хурлын нөхөн сонгуулийг Баянзүрх, Тосонцэнгэл сумдад зохион байгуулсан байна.

Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулах Хөвсгөл аймгийн сонгуулийн хороог аймгийн ИТХ-ын 2023 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Баянзүрх сумын Сонгуулийн хороог Баянзүрх сумын ИТХ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 6 дугаар захирамжаар, Тосонцэнгэл сумын сонгуулийн хороог Тосонцэнгэл сумын ИТХ-ын 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 12/02 дугаар тогтоолоор тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулахад нийт 50 төрийн албан хаагч ажилласан байна. Үүнд:

- Мэдээлэл технологийн багт 1;
- Аймгийн сонгуулийн хороонд 9;
- Сумын Сонгуулийн хороонд 10;
- Сумын хэсгийн хороонд 12;
- Мэдээлэл технологийн даамал 4;
- Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 3;
- Цагдаагийн байгууллагын алба хаагч 11;

Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийн зардалд Хөвсгөл аймагт 40,079.4 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилснаас 39,974.4 мянган төгрөгийг зарцуулж 105.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Аймгийн Сонгуулийн хорооны зардлын материалыг 2023 оны 7 сарын 7-ны өдөр Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар 4,750.0 мянган төгрөг, аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар 830.0 мянган төгрөг тус тус санхүүжиж зарцуулсан байна.

БҮЛЭГ 1:

Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийн батлагдсан төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Санхүүжилтийн хуваарийг журмын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна.

Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны 100170022001 тоот дансны 1 дүгээр гарын үсгийг сонгуулийн хорооны дарга Р.Машбат, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Амартүвшин нар зурж, санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1, 2.2 дахь заалтын дагуу улсын төсвөөс олгох Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны даргын 2023 оны А/19 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн сонгуулийн хороонд дараах байдлаар санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт №1			
№	Байгууллага	Албан бичгийн дугаар	Мөнгөн дүн /мян төг/
1	Сонгуулийн ерөнхий хороо	2023.04.28 №3/172	5,450.0
2	Сонгуулийн ерөнхий хороо	2023.06.05 №3/217	13,018.0
3	Сонгуулийн ерөнхий хороо	2023.06.12 №3/236	21,611.4
Нийт			40,079.4

Аймгийн сонгуулийн хорооны санхүүжилтийг Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу 2.2 дахь заалтын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж, баталсан байна.

Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны төсвийг нэр төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №2

№	Зардлын нэр	Төсөв /мян.төг/
1	Маягт хэвлүүлэх зардал	130.0
2	Үнэмлэх хэвлэх зардал	70.0
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	380.0
4	МТБ, даамлын сургалтын зардал	50.0
5	Бичиг хэргийн зардал	800.0
6	Шуудан, холбооны зардал	900.0
7	Унааны зардал	2,940.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	600.0
9	Сурталчилгааны зардал	1,000.0
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	5,198.0
11	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	170.0
12	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240.0
13	Мэдээ дамжуулах унааны зардал	210.0
14	Томилолтын зардал	2,836.0
15	Болзошгүй зардал	1,000.0
16	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	18,600.0
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,000.0
18	Саналын хуудас устгах зардал /хууль харах/	1,955.4
НИЙТ ДҮН		40,079.4

Сонгууль зохион байгуулах зардлын 44.6 хувийг сонгуулийн хороо, мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулал, хоолны зардал, 55.4 хувийг бусад зардал эзэлж байна.

1.2 Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журамд заасан үзүүлэлтийг харгалзан сумдад хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилан ирүүлсэн санхүүжилтийг аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3 “Аймаг нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар аргачлал, байгуулагдсан сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна” гэсэн заалтын дагуу сумын хэсгийн хорооны тоо болон түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн аргачлал, зөвлөмжийн дагуу Баянзүрх, Тосонцэнгэл сумын сонгуулийн хороодод дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №3

№	Сумын нэр	Мөнгөн дүн /мян.төг/
1	Баянзүрх	10,021.0
2	Тосонцэнгэл	11,321.0
3	Аймгийн Сонгуулийн хороо	18,637.4
	ДҮН	40,079.4

Аймгийн Сонгуулийн хороонд 18,637.4 мянган төгрөгийг, сумдын сонгуулийн хороонд 21,442.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1003 дугаар тушаалаар 4,750.0 мянган төгрөг хуваарилсан байна.

Аймгийн Цагдаагийн газарт орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах зардалд Цагдаагийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн албаны 2023.06.15-ны 6/6116 тоот албан бичгээр 830.0 мянган төгрөг хуваарилагдсан байна.

БҮЛЭГ 2: Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна.

2.1 Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж 105.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 3/172 дугаар албан тоот, 06 дугаар сарын 05-ний өдрийн 3/217 дугаар албан тоот, 6 дугаар сарын 12-ны 3/236 албан тоотоор тус тус сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг аймгийн сонгуулийн хороонд ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хороо сонгууль зохион байгуулах зардлаас 105.0 мянган төгрөг хэмнэж СЕХ-д төвлөрүүлсэн байна. Үүнд:

/Хүснэгт-4/			
д/д	Зардлын нэр	Дүн /мянган төгрөг/	Хэсгийн хорооны нэр
1	Мэдээ дамжуулах унааны зардал	105.0	Баянзүрх сумын сонгуулийн хороо
	Нийт дүн	105.0	

Аудитын хугацаанд аймгийн сонгуулийн хороо, Баянзүрх, Тосонцэнгэл сумдын сонгуулийн хорооны зардлын тайлан, санхүүгийн анхан шатны баримт материалыг татаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс хуваарилсан зардлаас аймгийн Сонгуулийн хорооны шатахууны зардалд зарцуулсан 700.0 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу байсныг аудитын хугацаанд залрууллаа.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг аймгийн сонгуулийн хороо Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.1 дэх хэсэгт “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын дансны гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасны дагуу сонгуулийн зардлын гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хорооны зардлын тайлан

/Хүснэгт 5/				
Д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт хэвлүүлэх зардал	130.0	130.0	-
2	Үнэмлэх хэвлэх зардал	70.0	70.0	-
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	380.0	380.0	-
4	МТБ, даамлын сургалтын зардал	50.0	50.0	-
5	Бичиг хэргийн зардал	800.0	800.0	-
6	Шуудан, холбооны зардал	900.0	900.0	-
7	Унааны зардал	2,940.0	2,940.0	-
8	Санал авах байр бэлтгэх зардал	600.0	600.0	-
9	Сурталчилгааны зардал	1,000.0	1,000.0	-
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	5,198.0	5,198.0	-
11	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	170.0	170.0	-
12	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240.0	240.0	-
13	Мэдээ дамжуулах унааны зардал	210.0	105.0	105.0
14	Томилолтын зардал	2,836.0	2,836.0	-
15	Болзошгүй зардал	1,000.0	1,000.0	-
16	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	18,600.0	18,600.0	-
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,000.0	3,000.0	-
18	Саналын хуудас устгах зардал /хууль харах/	1,955.4	1,955.4	-
	НИЙТ ДҮН	40,079.4	39,974.4	105.0

Аймгийн Сонгуулийн хороо нь орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон батлагдсан зардлаас мэдээ дамжуулах унааны зардлыг 105.0 төгрөгөөр хэмнэж нийт 105.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах зардлыг Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар олгож журмын дагуу зарцуулсан байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэл

/Хүснэгт 6/

д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Улсын бүртгэлийн ажилтны мөнгөн урамшуулал, НДШ-ийн зардал	1,800.0	1,800.0	-
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх зардал	166.0	166.0	-
3	Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх зардал	436.0	436.0	-
4	Томилолт унааны зардал	1,796.0	1,796.0	-
5	Техник хэрэгслийг тээвэрлэх зардал	552.0	552.0	-
	ДҮН	4,750.0	4,750.0	

Улсын бүртгэлийн хэлтэс нь орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахаар батлагдсан зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын
сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэл

/Хүснэгт 7/

д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Цагдаагийн ажилтны хоолны мөнгө	320.0	320.0	-
2	Шатахууны зардал	400.0	400.0	-
3	Шуудан холбооны зардал	110.0	110.0	-
	ДҮН	830.0	830.0	

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар нь орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахаар батлагдсан зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10 дахь хэсэгт заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж, дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

1. Сумын сонгуулийн хороонд санхүүжилт олгох бүртээ хөрөнгө зарцуулах талаар тайлбар, зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.
2. Орон нутгийн нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтэд аймаг сумдын төрийн санд түр данс нээж, төсвийг хуваарилан, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээгээр нь зардлын эрхийг нээж хяналт тавьж ажилласан байна. Аймаг, сумдын сонгуулийн зардлын баримт материалыг архивын нэгж болгон үдэж цэгцэлсэн байна.
3. Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод төсөв зарцуулалт болон бүрдүүлэх анхан шатны баримт, урамшуулал, унаа хоолны мөнгө, томилолтын зардал тооцох зэрэгт нэгдсэн тайлбар чиглэлийг хүргүүлэн ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулахаар батлагдсан төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
2. Аймгийн сонгуулийн хороо орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох хууль, журмын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТАЙЛАН

2023-06-30

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл			Гүйцэтгэл	Үлдэгдэл
			Баянзүрх	Тосонцэнгэл	Хө.Сонгуулийн хороо		
1	Маягт хэвлүүлэх зардал	130,000	50,000	50,000	30,000	130,000	-
2	Үнэмлэх хэвлэх зардал	70,000			70,000	70,000	-
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	380,000			380,000	380,000	-
4	МТБ, даамлын сургалтын зардал	50,000			50,000	50,000	-
5	Бичиг хэргийн зардал	800,000	250,000	250,000	300,000	800,000	-
6	Шуудан, холбооны зардал	900,000	300,000	300,000	300,000	900,000	-
7	Унааны зардал	2,940,000	910,000	910,000	1,120,000	2,940,000	-
8	Санал авах байр бэлтгэх зардал	600,000	270,000	270,000	60,000	600,000	-
9	Сурталчилгааны зардал	1,000,000	500,000	500,000		1,000,000	-
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	5,198,000	516,000	516,000	4,166,000	5,198,000	-
11	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	170,000			170,000	170,000	-
12	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	240,000	120,000	120,000		240,000	-
13	Мэдээ дамжуулах унааны зардал	210,000		105,000		105,000	
14	Томилолтын зардал	2,836,000			2,836,000	2,836,000	-
15	Болзошгүй зардал	1,000,000	500,000	500,000		1,000,000	-
16	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	18,600,000	5,400,000	6,600,000	6,600,000	18,600,000	-
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,000,000	1,200,000	1,200,000	600,000	3,000,000	-
18	Саналын хуудас устгах зардал	1,955,400			1,955,400	1,955,400	
19	Төвлөрүүлэх	-				-	105,000
НИЙТ ДҮН		40,079,400	10,016,000	11,321,000	18,637,400	39,974,400	105,000

ТАЙЛАН ГАРГАСАН: ХӨ.СОНГУУЛИЙН ХОРОО НЯГТЛАН БОДОГЧ

/Д.АМАРТҮВШИН/

ТАЙЛАН ХЯНАСАН: ХӨ.СОНГУУЛИЙН ХОРОО ДАРГА

/Р.МАШБАТ/



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

Нутгийн удирдлагын ордон, 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.
Утас: (976) 7038 2764, Факс: (976) 7038 2554,
Цахим шуудан: aimginihural@khs.gov.mn
Цахим хуудас: Khovsgol.Khural.mn

2023.07.18 № 14
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн аудитын газраас ирүүлсэн Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, хуваарилалт гүйцэтгэл” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төслийг дэмжиж байна.



ДАРГА

Р.МАШБАТ